



Захирлын 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 30 тоот тушаалаар батлав.

**ОЛОН УЛСАД МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН
ОЛОН УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ БИЗНЕСИЙН ДЭЭД СУРГУУЛЬД
2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг: Нийтлэг үндэслэл

- 1.1 Олон Улсын Эдийн Засаг Бизнесийн Дээд Сургууль /ОУЭЗБДС/ 2018-2019 оны хичээлийн жилд оюутан элсүүлэхдээ БШУ-ны Сайдын 2013 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/79 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Оюутан элсүүлэх журам”, БСШУС-ын Сайдын 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/194 тоот “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тушаал, А/195 тоот “Босго оноо тогтоох тухай” тушаал, 2018 оны 6-р сарын 19-ний өдрийн А/391 тоот тушаал бусад холбогдох эрх зүйн акт болон энэхүү журмыг баримтална.
- 1.2 ОУЭЗБДС-ийн бакалаврын хөтөлбөрт элсүүлэх элсэгчийн хяналтын тоог Удирдах зөвлөл тогтооно.
- 1.3 Элсэлтийн үйл ажиллагааг ОУЭЗБДС-ийн захирлын 2017 оны 94 тоот тушаалаар батлагдсан Элсэлтийн комисс удирдан зохион байгуулна.
- 1.4 Элсэлтийн комисс, гишүүн тус бүрийнхээ ажил үүргийг хуваарилан, элсэлтийн сурталчилгаа, элсэлтээр ажиллах багш нарын хуваарь, элсэлтийн үед баримтлах хэм хэмжээ, элсэгчдийн бүртгэл, өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэх болон элсэлтийн үйл явц, түүнд тавих хяналтын үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулж, ил тод, шударга, хүртээмжтэй, тэгш байх нөхцлийг бүрдүүлэн ажиллана.
- 1.5 Элсэгчдийн сурах ерөнхий чадвар, мэдлэгийн түвшин тогтоох зорилго бүхий Ерөнхий шалгалтыг Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас эрх олгосон хөндлөнгийн байгууллага зохион байгуулах бөгөөд уг байгууллага нь шалгалтын асуулт боловсруулах, олшруулах, нууцлалыг хадгалах, зохион байгуулах, оноог иргэдэд болон сургуульд мэдэгдэх, шалгалттай холбоотой бүхий л мэдээллээр хангах зэрэг үүргийг хүлээнэ.
- 1.6 Энэхүү журам болон элсэлтийн ажлын зохион байгуулалттай холбоотой нэмэлт мэдээллийг ОУЭЗБДС-ийн www.iieb.mn гэсэн вэб хуудсанд байршуулна.

Хоёр: Элсэгчдэд тавигдах нийтлэг шаардлага

- 2.1 ОУЭЗБДС-д элсэхийг хүсэгчид бүрэн дунд буюу түүнээс дээш боловсрол эзэмшсэн байна.
- 2.2 Хөдөө орон нутгаас элсэхийг хүсэгчид МИДСК-ын гишүүн их, дээд сургууль, коллежид аймаг, орон нутгаас 2018-2019 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх журмын дагуу заасан хугацаанд холбогдох материалыг бүрдүүлнэ.
- 2.3 ОУЭЗБДС-д элсэхийг хүсэгч нь Боловсролын Үнэлгээний төвөөс зохион байгуулсан Монгол хэл, бичгийн болон элсэхийг хүссэн хөтөлбөр, мэргэжил, бүлэгт заасан хичээлийн Ерөнхий шалгалтыг өгсөн байвал зохино.
- 2.4 ОУЭЗБДС-д элсэхийг хүсэгч нь Ерөнхий шалгалтанд аль нэг хичээлээр 410 буюу түүнээс дээш оноо авсан байна. (Боловсролын үнэлгээний төвөөс олгосон 2016, 2017 оны ЭЕШ-ын батламжийн оноогоор бүртгүүлж хөтөлбөр сонгож болно. ЭЕШ-ын оноог ахиулах зорилгоор 2018 онд дахин ЭЕШ өгсөн тохиолдолд илүү оноотой зөвхөн нэг батламжаар бүртгүүлж болно.)
- 2.5 Эрүүл мэндийн хувьд тус сургуульд элсэхэд харшлах зүйлгүй байна.
- 2.6 ОУЭЗБДС өмнө нь дээд болон тусгай дунд, бүрэн дунд боловсрол эзэмшсэн хүнийг холбогдох мэргэжлээр бакалаврын зэрэг олгох эчнээгийн хөтөлбөрт, бакалаврын боловсролтой элсэгчийг магистрын хөтөлбөрт, магистрын зэрэгтэй иргэнийг докторын хөтөлбөрт тус тус зохих хууль тогтоомжийн дагуу элсүүлж суралцуулна.

Гурав: Оюутан элсүүлэх хөтөлбөр, мэргэжлийн чиглэл, сургуулийн онцлог

- 3.1 ОУЭЗБДС 2018-2019 оны хичээлийн жилд тухайн Ерөнхий шалгалтын энэхүү журмын 2.4-т заасан оноог баримтлан бакалаврын дор заасан хөтөлбөр, мэргэжлүүдээр оюутан элсүүлнэ. Шалгуулагчид Ерөнхий шалгалт өгөх хичээлийг жагсаалтанд байгаа хичээлээс өөрсдөө сонгоно. Үүнд:

Бакалаврын өдрийн хөтөлбөр

№	Хөтөлбөрийн нэр	Мэргэжлийн чиглэл	Суралцах хугацаа /жил/	Сургалтын хэлбэр	Ерөнхий шалгалт өгөх хичээл
1	Эдийн засаг	Олон улсын эдийн засагч /бакалавр/	4	Өдөр	Математик, Нийгмийн тухай мэдлэг, Гадаад хэл, Монгол хэл
2	Бизнесийн удирдлага	Олон улсын худалдааны менежер /бакалавр/	4		
3	Санхүү, банк	Олон улсын банк	4	Өдөр	Математик,

		санхүүгийн мэргэжилтэн-нягтлан бодогч /бакалавр/			Нийгмийн тухай мэдлэг, Гадаад хэл, Физик
		Олон улсын гааль, татварын мэргэжилтэн /бакалавр/	4		
		Олон улсын санхүү-валютын эдийн засагч /бакалавр/	4		
		Даатгалын эдийн засагч /бакалавр/	4		
4	Нягтлан бодох бүртгэл	Нягтлан бодогч /бакалавр/	4	Өдөр	Математик, Нийгмийн тухай мэдлэг, Гадаад хэл, Физик
		Татварын эдийн засаг-нягтлан бодогч /бакалавр/	4		
5	Програм хангамж	Компьютерийн програм хангамжийн мэргэжилтэн /бакалавр/	4		Математик, Гадаад хэл, Физик, Нийгмийн тухай мэдлэг
6	Уул уурхайн ашиглалтын технологи	Уул уурхайн ашиглалтын технологич инженер /бакалавр/	4	Өдөр	Физик, Математик, Хими, Биологи, Гадаад хэл, Газар зүй
7	Механик инженер	Уул уурхайн машин тоног төхөөрөмжийн инженер /бакалавр/	4		
8	Ашигт малтмалын баяжуулалтын технологи	Ашигт малтмалын баяжуулалтын технологич инженер /бакалавр/	4		
9	Менежмент	Үйлдвэрлэлийн менежер /бакалавр/	4		
		Хүний нөөцийн менежмент /бакалавр/	4		
		Олон улсын аялал жуулчлалын менежер /бакалавр/	4		
10	Гадаад хэлний орчуулга	Япон-Англи хэлний орчуулагч /бакалавр/	4	Өдөр	Нийгмийн тухай мэдлэг, Гадаад хэл, Монгол хэл, Монгол улсын түүх
		Солонгос-Англи хэлний орчуулагч /бакалавр/	4	Өдөр	
		Хятад-Англи хэлний орчуулагч /бакалавр/	4	Өдөр	
11	Түүх, археологи	Олон улсын харилцааны ажилтан /бакалавр/	4	Өдөр	
12	Олон улсын эдийн засаг болон нийгмийн		4.5	Өдөр	

	ухааны чиглэлээр Монгол, Сингапурт 2,5 жил, дараа нь АНУ-д шилжин 2 жил сурч АНУ-ын дипломтой төгсөх 20 гаруй мэргэжлийн ангиуд /бакалавр/			хэл, Нийгмийн тухай мэдлэг
13	Олон улсын аялал жуулчлалын менежерийн ангид Монгол, Сингапурт, дараа нь Англид шилжин сурч Английн дипломтой төгсөх зочид буудлын менежер /бакалавр/	4.5	Өдөр	Газар зүй, Нийгмийн тухай мэдлэг, Гадаад хэл

Эчнээ /бакалавр/ болон магистр, докторын хөтөлбөр

№	Хөтөлбөрийн нэр	Мэргэжлийн чиглэл	Суралцах хугацаа /жил/	Сургалтын хэлбэр	Шалгалт өгөх хичээл
1	Бизнесийн удирдлага	Олон улсын худалдааны менежер /бакалавр/	4.5	Эчнээ	Математик, Гадаад хэл
		Олон улсын худалдааны менежер /бакалавр/	2.5	Эчнээ	
2	Санхүү, банк	Олон улсын банк санхүүгийн мэргэжилтэн-нягтлан бодогч /бакалавр/	2.5	Эчнээ	Математик, Гадаад хэл
		Олон улсын банк санхүүгийн мэргэжилтэн-нягтлан бодогч /бакалавр/	4.5	Эчнээ	
3	Бизнесийн удирдлага /магистр/		1.5	Өдөр	Мэргэжил, Гадаад хэл
4	Санхүү, банк, даатгал /магистр/		1.5	Өдөр	
5	Бизнесийн удирдлага /докторын сургалт/		5	Өдөр	
6	Санхүү банк, даатгал /докторын сургалт/		5	Өдөр	

3.2 Элсэгчид сургуулийн онцлог, сургалтын хөтөлбөрийн чиглэлийг харгалзан мэргэжлээ

сонгохдоо манай сургуулийн дор дурдсан онцлогт анхаарлаа хандуулахыг хүсье. Үүнд:

- 2017 оны 06-р сард АНУ-ын ACBSP магадлан итгэмжлэлийн байгууллагаар эдийн засаг, бизнесийн бүх хөтөлбөрөө магадлан итгэмжлүүлж манай сургуулийн диплом олон улсад хүлээн зөвшөөрөгдөх болсон.
- ОУЭЗБДС нь олон улсын эдийн засаг, бизнесийн чиглэлээр дагнан мэргэшсэн Монгол Улс дахь анхны дээд сургууль тул дэлхийн эдийн засаг, санхүү, банк, гааль, татвар, нягтлан бодох бүртгэл, худалдаа, аялал жуулчлал, менежмент, хөрөнгө оруулалт, валют санхүүгийн тогтолцоо зэрэг хичээлүүдийг олон улсын стандарттай нягт холбон хөтөлбөртөө тусган онол, практикийн гүнзгий мэдлэг, чадварыг оюутнуудад олгодог.

- Англи, Япон хэл, Компьютерийн мэдлэг, дадлагыг бүтэн 4 жилийн сургалтаар олгодог.
- Дийлэнх хөтөлбөрөөрөө хос мэргэжил эзэмшүүлдэг.
- 150 компьютер бүхий 6 лабораторитой. Сургуулийн орчинд интернетийн wireless сүлжээтэй.
- Нягтлан бодох бүртгэлийн DIAMOND програмын кейс сургалт явуулж мэргэжлийн компанийн батламж олгодог.
- Уул уурхайн цахилгаан механикийн орчин үеийн лаборатори, 5 кабинеттай.
- Гадаад хэлний сургалтын лингафоны кабинеттай.
- Оюутнуудад зориулсан өөрийн дотуур байр, спорт заалтай.
- Практик сургалт дадлагын, Япон судлалын, Эдийн засгийн судалгааны, Кейс сургалтын, Оюутны хөдөлмөр эрхлэлтийн төвүүдтэй.
- Гадаад харилцаа, хамтын ажиллагаа сайтай. Хүлээн авагч талын зардлаар сүүлийн жилүүдэд 60 шахам оюутныг Япон улсад дадлага хийлгээд байна.
- БНХАУ-ын Бээжин хот дахь Умард Хятадын Технологийн их сургуультай хамтран 2+2 хөтөлбөрт хамрагдан хоёр сургуулийн дипломтой төгсөх боломжтой.
- Умард Хятадын Технологийн их сургууль болон Япон улсын Фукуока хотын Хэл судлалын Академийн өвөл, зуны сургалтад хамрагдах боломжтой.
- Байгуулагдсанаас хойш сургалтын орчин бүрэн шинэчлэгдсэн боловч сургалтын зардал харьцангуй хямд хэвээр байгаа. Оюутнууддаа элсэлтийн онооны, сургалтын төлбөрөө хугацааны өмнө төлсний, сурлага, спорт, урлагийн амжилтын зэрэг 20 шахам төрлийн 5-100 хүртэл хувийн сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлдэг. Үүсгэн байгуулагчийн тэтгэлэг олгодог.

Дөрөв: Элсэхийг хүсэгчдийг бүртгэх

4.1 ОУЭЗБДС-д элсэхийг хүсэгчдийн бүртгэлийг 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн 2018 оны 07 дугаар сарын 27-ны Баасан гарагийг дуустал явуулж, тэнцсэн элсэгчдэд тухай бүрт нь хариу өгч, суралцах эрхийн бичиг олгоно. 2018 оны элсэгчдийн бүртгэлийн хураамж 5000 төгрөг, эрхийн бичгийг буцаасан тохиолдолд хураамж 10000 төгрөг байна.

4.2 Хөдөө орон нутгаас элсэгчдийн хувьд сургуулийн элсэгчдийн бүртгэл болон хуваарь сонголтыг “Монголын их, дээд сургуулиудын Консорциумын гишүүн их, дээд сургууль, коллежид аймаг орон нутгаас оюутан элсүүлэх журам”-ыг баримтлан, МИДСК-аас томилогдсон Элсэлтийн комисс болон сургуулиас томилогдсон элсэлтийн төлөөлөгч зохион байгуулна.

4.3 Элсэхийг хүсэгч нь Ерөнхий шалгалтыг тухайн хичээлээр хэдэн оноотой өгсөн болон ОУЭЗБДС-д ямар мэргэжлээр суралцах зэргээ тодорхой бичиж гарын үсэг зурж баталгаажуулсан өргөдөл бичиж Элсэлтийн комисс болон Элсэлтийн төлөөлөгчид өгнө.

4.4 Элсэхийг хүсэгч нь ОУЭЗБДС-ийн сургалт явуулах хэд хэдэн мэргэжлээс сонголт хийж элсэх өргөдөл өгч болно.

4.5 2017-2018 оны хичээлийн жилд ОУЭЗБДС-иас зохион байгуулсан АХА тэмцээнд идэвхитэй оролцож тус сургуульд элсэн суралцах урилга авсан, элсэлтийн босго оноог хангасан шалгуулагчийг тэргүүн эгнээнд элсүүлнэ.

4.6 Элсэхийг хүсэгч бүртгүүлэхдээ дараах материалыг бүрдүүлсэн байна.

Үүнд:

- Өөрийн гараар бичсэн өргөдөл
- Монгол хэл, бичгийн эрхийн бичиг /эх хувь/
- Ерөнхий шалгалтын батламж /эх хувь/
- Боловсролын үнэмлэх, гэрчилгээ, диплом /эх хувь/
- Суралцагчийн хувийн хэрэг /эх хувь/
- Иргэний үнэмлэх болон түүнтэй адилтгах бичиг баримт /эх хувь/
- Элсэхийг хүсч байгаа чиглэлээрээ улсын чанартай уралдаан тэмцээн, олимпиад зэрэгт үзүүлсэн амжилтын тухай материал зэргийг бүрдүүлж өгсөн байна.

Тав: Элсэгчдийг шалгаруулах ба хөтөлбөр сонгох

5.1 Элсэхийг хүсэгчдийн Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон сурч боловсрох эрхийг хүндэтгэж Ерөнхий шалгалт өгсөн тохиолдолд ОУЭЗБДС-д элсэх хүсэлтийг хүлээн авна. Тус сургуулийн Элсэлтийн комисс элсэхийг хүсч өргөдлөө ирүүлсэн хүмүүсийн бичиг баримт материалтай танилцаж, элсэгчдийн Ерөнхий шалгалтын дүнг харгалзан, хяналтын тоонд багтаан сонгон шалгаруулалт хийж элсүүлнэ.

5.2 Шалгуулагчдыг аймаг бүрээр холбогдох хөтөлбөр, мэргэжлийн чиглэлээр бүлэг болгон онооны дарааллаар жагсааж батлагдсан хяналтын тоонд багтаан элсүүлнэ.

5.3 Шалгалтын оноо тэнцсэн тохиолдолд боловсролын гэрчилгээнд бичигдсэн хичээлүүдийн дүнгийн дундажийг харьцуулан шийдвэрлэнэ.

5.4 Аймгуудад оногдсон тус сургуулийн хөтөлбөр, мэргэжлүүдээр оюутан элсүүлэх хяналтын тоонд багтсан хүмүүсээр мэргэжил сонгуулалтыг өргөдөл хүлээж авснаар хийж эхэлнэ.

5.5 Шалгаруулалт хийж тэнцсэн хүмүүсийн нэрсийг тухай бүр мэдээлнэ.

Зургаа: Элсэлттэй холбогдсон маргаан шийдвэрлэх

6.1 Элсэлттэй холбоотой гарсан өргөдөл, маргаан, гомдол, санал хүсэлтийг Элсэлтийн комисс хүлээн авч, 3 хоногийн дотор шийдвэрлэнэ.

6.2 Элсэлтийн комисс нь тухайн элсэгчийн санал гомдлыг хүлээн авч 3-5 хүний бүрэлдэхүүнтэй тухайн мэргэжлийн салбарын багш, ажилтнуудаас бүрдсэн баг гаргаж, маргааныг шийдвэрлэнэ.

6.3 Ерөнхий шалгалттай холбоотой маргааныг тус сургууль, болон Элсэлтийн комисс хариуцахгүй болно.

Долоо: Хөнгөлттэй нөхцлөөр элсүүлэх

7.1 Элсэлтийн ерөнхий шалгалтанд 800 оноо авсан тус сургуулийн элсэгчид эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийн 100%, 700-799 оноо авсан бол 50%, 651-699 хүртэл оноо авсан элсэгчид 30%, 600-650 оноо авсан бол 20%, 500-599 оноо авсан элсэгчид 10%-ийн хөнгөлөлт тус тус үзүүлнэ.

7.2 ЭЕШ-ын босгыг хангасан, улсын болон олон улсын чанартай уралдаан, олимпиадад 1-5-р байр эзэлсэн элсэгчийг сонирхсон хөтөлбөр, мэргэжлээр нь эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийн 10-50%, улсын болон олон улсын чанартай урлаг, спортын наадмуудад 1-3-р байр эзэлсэн элсэгчийг 5%, спортын I зэрэг болон түүнээс дээш зэрэгтэй бол 5%-ийн хөнгөлөлттэй тус тус элсүүлэн суралцуулна.

7.3 Ерөнхий боловсролын сургуулийг А үнэлгээтэй төгссөн, ЭЕШ-ын босгыг хангасан элсэгчийг Элсэлтийн комиссын шийдвэрээр урилгаар элсүүлнэ.

7.4 Хөнгөлөлттэй нөхцөлөөр элсэхийг хүсэгчид өргөдөл болон анкет, нотлох баримт бичгүүдээ бүрдүүлэн хүсэлтээ Элсэлтийн комисст ирүүлнэ.

7.5 Суралцагч энэ журамд заасан хоёр болон түүнээс дээш болзлыг биелүүлсэн нөхцөлд зөвхөн хамгийн өндөр нэг хөнгөлөлтийг эдэлнэ.

Найм: Элсэгчдийг бүртгэх

8.1 Элсэлтийн шалгаруулалтад тэнцсэн элсэгчдийг 2018 оны 08 дугаар сарын 27-31-ний хооронд дэлгэрэнгүй бүртгэлд хамруулна.

8.2 Элсэгч дэлгэрэнгүй бүртгэлд хамрагдахдаа дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

- Иргэний үнэмлэх, эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг эх хувь, хуулбарын хамт
- Сургуулийн тодорхойлолт
- Суралцах эрхийн бичиг /эх хувь/
- 3x4 хэмжээний 4 % цээж зураг
- Суурь боловсролын гэрчилгээ /эх хувь/
- Сургалтын төлбөр төлсөн баримт /эх хувь/
- Оюутны хөгжлийн зээл, буцалтгүй тусламжаар суралцах бол холбогдох материал

8.3 Дурдсан хугацаанд ирж дэлгэрэнгүй бүртгэлд хамрагдаагүй болон бүртгүүлэх боломжгүй тохиолдолд хүндэтгэх шалтгаанаа урьдчилан мэдэгдээгүй элсэгчийн суралцах эрхийг цуцалж, баримт бичгийг холбогдох журмын дагуу буцаан олгоно.

8.4 Элсэлтийн материалыг хуурамчаар бүрдүүлсэнтэй холбогдон гарах хариуцлагыг элсэгч өөрөө хүлээнэ.



(БСШУС-ын сайдын 2018 оны А/391 тоот тушаалыг үндэслэн 2018.06.22-ны өдөр журамд нэмэлт өөрчлөлт оруулан батлав.)

-----oOo-----